



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын I цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/040/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор: Д.Нарантуул Утас:99019800 Цахим хаяг: ntuul9800@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024.02.13 № 87
танай _____-ны № _____-т

БУЛГАН СУМЫН I ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ У.УРАНЧИМЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын I цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Булган сумын I цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Амралт цалин давхардуулан бодсон, албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг Засгийн газрын тогтоолоос илүү хувиар тооцон олгосон, хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэмжтэй хугацаанд цалинг давхардуулан олгосон 11.8 сая төгрөг,
- Дотоод хяналтгүйгээс Боловсрол мэдээллийн esis.edu.mn систем дэх хүүхдийн ирцийн цахим бүртгэл багш нарын журнал дахь бүртгэл зөрүүтэй, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан зөрүүтэй тайлагнасанатай холбоотой 54.2 сая төгрөг, зэрэг алдаа, зөрчлүүд байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6.дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан,

гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; ажилтан хариуцна", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2.орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх; 32.2.3.нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх; Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 3.6-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ", 3.7-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна" 3.7.1-д "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах", Боловсрол шинжлэх ухааны яамны 2020 оны 3/1557 дугаар албан бичиг "Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем"-ийн www.esis.edu.mn цахим системийг ашиглан бүртгэх тухай" гэсэн заалтуудыг мөрдөөгүй иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд хүүхэд өдрийн төлөвлөгөө 54,151 хүүхэд өдрөөр батлагдаж гүйцэтгэлээр 37,751 хүүхэд өдөр буюу 69.7 хувьтай, улсын төсвөөс 1,481,105.2 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч гүйцэтгэлийн үнэлгээнд 1 дүгээр түвшинд 2 багш, 2 дугаар түвшинд 2 багш, 3 дугаар түвшинд 3 багш, 4 дүгээр түвшинд 6 багш үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>314,330,476.55</u>	<u>166,577,197.06</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	191,168,000.93	63,855,870.06
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	191,168,000.93	63,855,870.06
3121	Төгрөг	191,168,000.93	63,855,870.06
31211	Төрийн сангийн харилцах	191,168,000.93	63,855,870.06
35	БАРАА МАТЕРИАЛ	123,162,475.62	102,721,327
354	Хангамжийн материал	123,162,475.62	102,721,327
35410	Бичиг хэргийн материал	1,928,510	270,000
35420	Аж ахуйн материал	120,142,365.62	102,451,327.00
35450	Барилгын засварын материал	1,071,600	-
35460	Хүнсний материал	20,000	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,008,048,515.29</u>	<u>982,869,105.67</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,008,048,515.29	982,869,105.67
392	Биет хөрөнгө	997,448,515.29	972,269,105.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	968,439,250	968,439,250
39202	Хуримтлагдсан элэгдэл	(86,677,258.68)	(102,817,912.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	63,635,978	76,921,756
39206	Хуримтлагдсан элэгдэл	(55,280,313.67)	(52,645,462.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	161,983,738.24	149,880,198.24
39208	Хуримтлагдсан элэгдэл	(93,458,811.99)	(101,954,656.91)
39214	Бусад үндсэн хөрөнгө	41,850,000	41,850,000
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,786,666.61)	(11,146,666.73)
39217	Ном	3,742,600	3,742,600
393	Биет бус хөрөнгө	10,600,000	10,600,000
39301	Програм хангамж	275,000	275,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(275,000)	(275,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,600,000	10,600,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,322,378,991.84</u>	<u>1,149,446,302.73</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,154,414.37</u>	<u>32,615,038.40</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,154,414.37	32,615,038.40
413	Өглөг	1,154,414.37	32,615,038.40
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,154,414.37	31,457,200.40
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,157,838
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,321,224,577.47</u>	<u>1,116,831,264.33</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,321,224,577.47	1,116,831,264.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	205,511,552	205,511,552
51101	Өмч: - төрийн	205,511,552	205,511,552
512	Хуримтлагдсан үр дүн	475,170,543.55	270,777,230.41
51210	Өмнөх үеийн үр дүн	475,170,543.55	474,207,023.55
51220	Тайлант үеийн үр дүн	-	(203,429,793.14)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	640,542,481.92	640,542,481.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,322,378,991.84</u>	<u>1,149,446,302.73</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,990,843,944	1,604,904,253.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	91,660,644	20,425,353.91
120	Нийтлэг татварын бус орлого	91,660,644	20,425,353.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,911,544	20,425,353.91
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	65,911,544	20,425,353.91
120009	Бусад орлого	25,749,100	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,899,183,300	1,584,478,900
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,822,566,900	1,481,105,200
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,822,566,900	1,481,105,200
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	800,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	800,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,616,400	102,573,700
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,616,400	102,573,700
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,841,692,666.85	1,791,708,780.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,841,692,666.85	1,791,708,780.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,823,981,026.85	1,782,837,861.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,313,683,558.74	1,298,498,074.19
210101	Үндсэн цалин	820,933,580.31	764,567,167.08
210102	Нэмэгдэл	417,221,910.60	428,234,687.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	38,605,000
210104	Урамшуулал	75,528,067.83	67,091,220
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	168,241,892.53	160,904,992.71
210201	Тэтгэврийн даатгал	111,418,445.47	113,002,373.40
210202	Тэтгэмжийн даатгал	13,075,411.29	11,988,167.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,644,944.57	6,470,144.27
210204	Ажилгүйдлийн даатгал	6,429,585.45	5,888,860.77
210205	Эрүүл мэндийн даатгал	29,673,505.75	23,555,446.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,244,800.00	101,122,919.35
210301	Гэрэл, цахилгаан	8,002,474.45	10,671,056.35
210302	Түлш, халаалт	66,344,375.55	66,591,063
210303	Цэвэр, бохир ус	897,950	23,860,800
2104	Хангамж, бараа материалын зардал	41,715,763	33,515,548.62
210401	Бичиг хэрэг	8,832,139	-
210402	Тээвэр, шатахуун	10,576,515	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	22,307,109	33,515,548.62
2105	Нормативт зардал	164,448,980	113,253,000
210502	Хоол, хүнс	164,448,980	113,253,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,361,200	3,451,300
210604	Урсгал засвар	1,361,200	3,451,300
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,755,081	3,877,650
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,755,081	3,877,650
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,529,751.58	68,214,377.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,338,464	24,711,750

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,088,000	9,235,650
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,103,287.58	34,266,977.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,711,640	8,870,918.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,711,640	8,642,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,711,640	8,642,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	228,918.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	228,918.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>149,151,277.15</u>	<u>(186,804,526.64)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	16,625,266.50
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	16,625,266.50
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(16,625,266.50)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>149,151,277.15</u>	<u>(203,429,793.14)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,924,932,400</u>	<u>1,584,478,900</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>25,749,100</u>	-
120	Нийтлэг татварын бус орлого	25,749,100	-
120009	Бусад орлого	25,749,100	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>1,899,183,300</u>	<u>1,584,478,900</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,822,566,900	1,481,105,200
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,822,566,900	1,481,105,200
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	800,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	800,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,616,400	102,573,700
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,616,400	102,573,700
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,789,468,803.08</u>	<u>1,711,791,030.87</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>1,789,468,803.08</u>	<u>1,711,791,030.87</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>1,771,757,163.08</u>	<u>1,702,920,112.22</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,297,324,709.08	1,280,457,182.66
210101	Үндсэн цалин	771,569,953.82	720,592,548.53
210102	Нэмэгдэл	419,344,435.75	428,249,049.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	38,509,234.96
210104	Урамшуулал	106,410,319.51	93,106,349.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	162,334,200	148,643,098.21
210201	Тэтгэврийн даатгал	110,387,200	101,077,399.21
210202	Тэтгэмжийн даатгал	12,986,700	11,891,399
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,493,400	5,945,700
210204	Ажилгүйдлийн даатгал	6,493,400	5,945,700
210205	Эрүүл мэндийн даатгал	25,973,500	23,782,900
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,244,800	99,965,081.35
210301	Гэрэл, цахилгаан	7,083,972.44	9,513,218.35
210302	Түлш, халаалт	67,262,877.56	66,591,063
210303	Цэвэр, бохир ус	897,950	23,860,800
2105	Нормативт зардал	141,944,490	113,233,000

210502	Хоол, хүнс	141,944,490	113,233,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,371,600	2,379,700
210604	Урсгал засвар	1,371,600	2,379,700
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,181,931	3,877,650
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,935,400	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,246,531	3,877,650
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,355,433	54,364,400
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,365,214	42,991,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,990,219	11,373,400
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,711,640	8,870,918.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,711,640	8,642,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,711,640	8,642,000
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	228,918.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	228,918.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	135,463,596.92	(127,312,130.87)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	135,463,596.92	(127,312,130.87)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	55,704,404.01	191,168,000.93
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	191,168,000.93	63,855,870.06

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(ТӨГРӨГӨӨР)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552	640,542,481.92	251,140,670.77	1,097,194,704.69
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,511,552	640,542,481.92	251,140,670.77	1,097,194,704.69
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	73,520,262.28	73,520,262.28
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552	640,542,481.92	475,170,543.55	1,321,224,577.47
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552	640,542,481.92	475,170,543.55	1,321,224,577.47
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(963,520)	(963,520)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,511,552	640,542,481.92	474,207,023.55	1,320,261,057.47
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	-203,429,791.50	-203,429,791.50
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,511,552	640,542,481.92	270,777,232.05	1,116,831,265.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(ТӨГРӨГӨӨР)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,769,823,600	1,711,562,112.22

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,769,823,600	1,711,562,112.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,760,394,500	1,702,920,112.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,300,586,700	1,280,457,182.66
210101	Үндсэн цалин	770,086,100	720,592,548.53
210102	Нэмэгдэл	470,118,100	428,249,049.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	38,509,234.96
210104	Урамшуулал	60,382,500	93,106,349.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,806,000	148,643,098.21
210201	Тэтгэврийн даатгал	109,782,500	101,077,399.21
210202	Тэтгэмжийн даатгал	13,005,900	11,891,399
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,502,900	5,945,700
210204	Ажилгүйдлийн даатгал	6,502,900	5,945,700
210205	Эрүүл мэндийн даатгал	26,011,800	23,782,900
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,965,100	99,785,081.35
210301	Гэрэл, цахилгаан	9,360,000	9,513,218.35
210302	Түлш, халаалт	65,652,100	66,591,063
210303	Цэвэр, бохир ус	24,953,000	23,680,800
2105	Нормативт зардал	134,755,300	113,233,000
210502	Хоол, хүнс	134,755,300	113,233,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,608,600	2,379,700
210604	Урсгал засвар	2,608,600	2,379,700
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,649,800	3,877,650
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,649,800	3,877,650
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,023,000	54,364,400
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,645,100	42,991,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,377,900	11,373,400
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,429,100	8,642,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,429,100	8,642,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,429,100	8,642,000
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,584,478,900	1,584,249,981.35
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,583,678,900	1,481,105,200
131001	Улсын төсвөөс санхүүжих	102,573,700	1,481,105,200
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,481,105,200	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	102,344,781.35
132001	Орон нутгийн төсвөөс	-	102,344,781.35
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	800,000	800,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	800,000	800,000
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	191,168,000.93
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	63,855,870.06
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42	42
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	29	29
620003	Үйлчлэх ажилтан	12	12
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42	42
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	29	29
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12

ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 145,071.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 73,369.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Авлагыг 1,000.0 мянган төгрөгөөр илүү,
- Тайлант онд худалдан авсан 1,249.0 мянган төгрөгийн БҮТЭЗ-ийг зарлагадаж бараа материалын үлдэгдэл зөрүүтэй илэрхийлсэн,
- 2025 оны 7 дугаар сард ноогдох амралтын цалинг, цалингийн санд оруулж тооцоогүйгээс нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ын тооцоог 28,837.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж өглөг дутуу тусгасан,
- Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардал, тайлант үеийн үр дүн 31,557.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Хөрөнгийн ангилал буруу сонгон 9,761.6 мянган төгрөгийн тавилга эд хогшлийг тоног төхөөрөмж дансанд бүртгэсэн,
- Өмнөх оны хөрөнгийн ашиглах жилийг хасах тэмдэгтэй утгаар оруулснаас тухайн оны хуримтлагдсан элэгдлийг 963.5 мянган төгрөгөөр дутуу тооцож, өмнөх үр дүн дансны бичилтийг орхигдуулсан,

Залруулагдаагүй нийт 71,702.3 мянган төгрөгийн 4 зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшинг 26,875.6 мянган төгрөгөөс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 71,702.3 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 11,843.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

3.1 ТӨЛБӨРИЙН АКТ

3.1.1 Цалин, орон нутгийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Багш, ажилчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг 2025 оны 01,02 дугаар сард тогтоолд заасан хувиас илүү тооцон 9,860,000, амралт цалин давхардуулан бодсон 1,365,187 төгрөг, хөдөмөрийн чадвараа түр алдсаны листтэй хугацаанд 617,770 төгрөгийг цалингийн сангаас олгож, амралтын цалин давхардуулан нийт 11,842,957 төгрөгийг зарцуулсан нь “Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;” 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 2-д “Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар ...,” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх;” 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5.1-д “Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсан хугацааны ажлын эхний таван өдрийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажил олгогчоос, зургаа дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсхүл хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацааны тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас тус тус олгоно, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны лист (эмнэлгийн магадалгаа) болон ажил олгогчоос

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

олгох цалинг давхардуулан олгохгүй бөгөөд нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авсан тохиолдолд тухайн өдрүүдийн цалинг ажил олгогч олгохгүй байх хууль эрх зүйн зохицуулалттай гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Хүүхдийн ирцийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Боловсрол мэдээллийн esis.edu.mn системд илгээсэн 2025 оны 03-12 саруудын хүүхдийн ирцийн тоо мэдээг байгууллагын багш нарын өдөр тутамд хөтөлдөг "бүлгийн ирц бүртгэл"-ийн журналын тоотой тулгахад 7476 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; "16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; БШУЯ-ны 2020 оны 3/1557 дугаар албан бчиг "Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем"-ийн www.esis.edu.mn цахим системийг ашиглан бүртгэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Боловсролын мэдээллийн esis.edu.mn цахим бүртгэлд тухай бүрд мэдээллийг үнэн зөв оруулж, ирцийн бүртгэлд тавих дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэн ажиллах

3.2.2 Дотоод хяналт, санхүүгийн тайлан гаргалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайлан гаргалт хангалтгүй, зарлагын ажил гүйлгээг мөнгөн гүйлгээний тайланд тухайн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй урсгал зардлаар, хүлээн зөвшөөрсөн тайлагнасан, аймгийн Засаг даргын захирамжаар цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаагаар хязгаарласан үед зардал гаргасан, ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд төсвөөс 5.2 сая төгрөг зарцуулсан ч ахмадын хороо, зөвлөлд танилцуулаагүй, журам боловсруулаагүй дотоод хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх;" 8.4. Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 3.6-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ", 3.7-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна" 3.7.1-д "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах", 3.7.3--д " илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын төлөвлөгөөнд тусгасны дагуу хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, санхүүгийн тайланг үнэн зөв гаргах талаар анхааран ажиллаж холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрийг мөрдөх

3.2.3 Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн 2025 оны 6-8 саруудын тайланд цалингийн санг 54,146,266 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нийгмийн даатгалын ерэнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-т “орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;”, 32.2.3-т “нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх;”, 32.2.-т нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтөлж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, мэдээг гарган энэ хуулийн 25.1-д заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэх;” гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын газарт хүсэлт уламжилж 2025 оны 6-8 саруудын тайланг засварлан ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Булган сумын I цэцэрлэг	6	73,369.5	2	32,521.4	4	40,848.1	6	73,369.5	-	-	-	-
Дүн	6	73,369.5	2	32,521.4	4	40,848.1	6	73,369.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Булган сумын I цэцэрлэг	4	71,702.3	1	11,843.0			3	59,859.3	-	-	-	-
Дүн	4	71,702.3	1	11,843.0	-	-	3	59,859.3	-	-	-	-

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	-	1	-	-
НИЙТ			1	-	-	-	1	-	-